



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/431

Булган сум

Майхантай аялагчдад зориулсан “Түр отоглох цэг”-н үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аялал жуулчлалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалт, 23 дугаар зүйлийн 23.1.1, 23.1.9, 23.1.12 дахь заалт, аймгийн Засаг даргын “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөрийн 1 дүгээр зүйлийн 1.8.1.6, 1.8.1.7 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аялал жуулчлалын идэвхтэй улиралд олон улсын чанартай төв зам дагуу, майхантай аялагч, жуулчдад зориулсан стандартын шаардлагад нийцсэн ЭКО ариун цэврийн байгууламж, хогийн цэг бүхий “Түр отоглох цэг”-ийн үйл ажиллагааг зохион байгуулсугай.

2. “Түр отоглох цэг” сонгон шалгаруулалтын ажлын хэсгийг 1 дүгээр, “Түр отоглох цэг”-н үйл ажиллагааг зохион байгуулахад шаардагдах төсвийг 2 дугаар хавсралтаар баталсугай.

3. “Түр отоглох цэг”-н үйл ажиллагааг эхлүүлэхэд шаардагдах төсөв болох 19,995,500 (арван есөн сая есөн зуун ерэн таван мянга таван зуу) төгрөгийг “Эрдэнэт үйлдвэр” Төрийн өмчит үйлдвэрийн газрын 2026 оны хамтын ажиллагааны төлөвлөгөөний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.


ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР

6326010587

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 16-ны/ний өдрийн
А/Б/31 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



“ТҮР ОТОГЛОХ ЦЭГ”-ИЙГ ХАРИУЦАХ ӨРХИЙГ
СОНГОН ШАЛГАРУУЛАХ АЖЛЫН ХЭСЭГ

- Ажлын хэсгийн ахлагч: Д.Эрдэнэбилэг (Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга)
- Гишүүд: Х.Ууганбаяр (Бугат сумын Засаг дарга)
Оюун-Эрдэнэ (Байгаль орчны газрын мэргэжилтэн)
Ш.Батнасан (Бугат сумын 2 дугаар багийн Засаг дарга)
Б.Отгонбаяр (Хойд бүсийн хөгжлийн төв төрийн бус байгууллагын Булган салбарын нарийн бичгийн дарга)
- Нарийн бичгийн дарга: Э.Эрдэнэжаргал (Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

--o00o--

Аймгийн Засаг даргын 2026 оны
06 дугаар сарын 16-ны/ний өдрийн
Х/НЗ дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



“ТҮР ОТОГЛОХ ЦЭГ”-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ШААРДАГДАХ ТӨСӨВ

дд	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ (төгрөгөөр)	Нийт үнэ (төгрөгөөр)
1	2	3	4	5
1	Замын дэргэдэх тэмдэг, тэмдэглэгээ	13	193,500	2,515,500
2	Мэдээллийн том самбар	13	70,000	910,000
3	Санамжийн самбар (Төлбөрийн мэдээлэл, санал хүсэлт авах QR код)	10	25,000	250,000
4	Танилцуулга, тараах материал	360	500	180,000
5	Хогийн сав (сараалжин төмөр)	10	250,000	2,500,000
6	Автомашин зогсоол болон майхан барих хязгаарлалт тогтоох уяа (цацруулагчтай)	10	80,000	800,000
7	Нарны эрчим хүчээр ажилладаг ЛЕД гэрэл	10	75,000	750,000
8	Замын хажуугаар шуудуу ухах зардал	1	3,000,000	3,000,000
9	Хяналт шалгалт болон бусад үндсэн үйл ажиллагааны зардал	6	250,000	1,500,000
10	Эко ариун цэврийн байгууламжийн хөнгөлөлт (20% хөнгөлөлт үндсэн үнэ 1,650,000)	23	330,000	7,590,000
Нийт дүн				19,995,500

--o00o--